



**БАТЛАВ**  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН**  
**ЗАХИРАЛ** **Ч.БАТ-ЭРДЭНЭ**

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН**  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**  
**(2015-2019)**

***(Шинэчлэн боловсруулав)***

*2015 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн ЭМХТ-ийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.*

**Улаанбаатар хот**

**2015 он**

## **Боловсруулахад ашигласан материал:**

1. Эрүүл мэндийн тухай МУ-ын хууль
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай МУ-ын хууль
3. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай МУ-ын хууль
4. МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
5. Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
6. “Эрүүл мэндийн салбарын Мастер төлөвлөгөө”, түүнийг хэрэгжүүлэх хүрээ
7. “ЭМХТ-ийн 2013-2016 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”
8. “ЭМХТ-ийн 2014-2016 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”
9. Төвийн дүрэм, бүтэц, чиг үүргийг баталсан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 79 дүгээр тушаал
10. “ЭМХТ-ийн Байгууллагын хөгжил хөтөлбөр”, 2013-2016 он
11. ЭМХТ-ийн 2014 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн үнэлгээний зөвлөмж

Шинэчлэн боловсруулсан:

Н.Нарангэрэл /ЗААА/

Хянаж, зөвлөсөн:

С.Дуламсүрэн /ШНЭМН/

## ӨМНӨХ ҮГ



**“ХҮН АРДЫН ЭРҮҮЛ ЭНХ”** хэмээх нэгэн их үйлсийн төлөө хүчин зүтгэж буй мэргэжил нэгтнүүддээ болон дэмжин ажилладаг хамтрагч талууддаа хувиасаа болон хамт олныхоо нэрийн өмнөөс мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энхийг хүсэн ерөөе.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн ажилтны мэдлэг, мэргэжил, мэргэшил болон ур чадварын хөгжлийг дэмжих, эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэх, шинэ мэдээлэл, мэдлэг үйлдвэрлэх замаар эрүүл мэндийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, үнэтэй хувь нэмэр оруулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 50 дугаар тогтоол, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 79 дүгээр тушаалаар шинэчлэн зохион байгуулагдаж шинэ бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажиллаж байгаа ч, эрүүл мэндийн салбартаа нэр хүндтэй, 19 жилийн хөгжлийн түүхэн замналыг туулсан арвин туршлагатай байгууллага юм.

Манай хамт олон эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэлийн түүхийг хамтран бичих нэгэн үеийг нээж, хүн ардынхаа эрүүл энхийн төлөө, мэдлэг, оюун, сэтгэл зүтгэл, цаг хугацаагаа зориулан ажиллана гэдгээ тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Хүн ардынхаа эрүүл энхийн төлөө зүтгэж буй мянга мянган эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид, үе үеийн ахмадууд, эрдэмтэн мэргэд, гавьяат алдартнууд, бүх хамтран ажиллагч байгууллага хүмүүс Та бүхний мэдлэг, ур чадвар, бүтээлч шинэ санаачлага, нэгдмэл үйл ажиллагааны үр дүнд манай байгууллагын **“ОНОВЧТОЙ ШИЙДЭЛ-ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЛ”** алсын хараа хэрэгжиж, тасралтгүй хөгжин дэвшинэ гэдэгт итгэж байна.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ**

**Ч.БАТ-ЭРДЭНЭ**

## **“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ (2015-2019)**

### **ТОДОРХОЙЛОЛТ**

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөр, стратеги, хууль, дүрэм журам, стандарт, удирдамжийг боловсруулахад шаардлагатай бодлогын судалгаа хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо мэдээллээр хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, шалгалт болон засвар тохируулгыг нэгдсэн байдлаар хийх, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, салбарын мэдээллийн технологи, зайн ангаах ухааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага юм.

### **АЛСЫН ХАРАА: ОНОВЧТОЙ ШИЙДЭЛ- ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЛ**

#### **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, хүний нөөц, технологийн чадамжийг нэмэгдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

#### **ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ:**

- Төрийн үйлчилгээ нь чанартай, шуурхай, ээлтэй байх
- Өндөр мэргэшсэн, чадварлаг хүний нөөцтэй байх
- Хууль ёсыг сахиж, хариуцлагатай ил тод байх
- Нэгдмэл үйл ажиллагаа, баг, удирдлагатай байх
- Оновчтой хөрөнгө оруулалт, мэдрэмжтэй хуваарилалттай байх
- Эрх тэгш, нээлттэй, сайн түншлэлтэй байх
- Үйл ажиллагаа нь тогтвортой, үр дүнтэй, үр ашигтай байх
- Байгууллагын соёл, үнэт зүйл, ёс зүйг эрхэмлэдэг байх

#### **АЖИЛЛАХ ЗАРЧИМ:**

- Үйлчлүүлэгчийг дээдлэх
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцыг чанд сахих
- Ил тод, нээлттэй ажиллаж
- Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийг мөрдлөг болгох

## СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1.

Бодлого, шийдвэрийн нотолгоо, мэдээллийн чанарыг сайжруулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1.1:** Эрүүл мэндийн бодлогын судалгааг өргөжүүлэн хөгжүүлэх

*Хүрэх үр дүн: Нотолгоонд үндэслэсэн оновчтой бодлого, шийдвэр гарсан байна.*

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Эрүүл мэндийн салбарын тогтолцооны судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг мэдээ, мэдээллээр хангах;
- Эрүүл мэндийн технологи, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, концессын төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлэх;

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1.2:** Эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээг сайжруулах

*Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн сайжирсан байна.*

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Эрүүл мэндийн нийт зардлын үндэсний тооцоо, санхүүжилтийн дүн шинжилгээ хийж хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1.3:** Эрүүл мэндийн статистик мэдээллийн агуулгыг боловсронгуй болгож, чанарыг сайжруулах

*Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн статистик мэдээллийн чанар сайжирсан байна.*

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Өвчний олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хэрэглээг сайжруулах ажлыг зохион байгуулах;
- Хүн амын эрүүл мэндийн мэдээний нэгдсэн цахим сан бүрдүүлэх, програм хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах;
- Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах;

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2:

Эрүүл мэндийн технологи, зайн анагаах ухааныг хөгжүүлэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.1:** Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, шалгалт болон засвар тохируулгын үйл ажиллагааг өргөжүүлэх

*Хүрэх үр дүн: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл хийгдэж, шалгалт болон засвар тохируулга хийгдсэн байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн сан үүсгэж, шалгалт болон засвар тохируулга хийх
- Тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.2:** Телемедициний үйлчилгээг өргөжүүлэх

*Хүрэх үр дүн: Телемедицины үйлчилгээний нэр төрөл олширч, тоо хэмжээ нэмэгдсэн байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Зайн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг зохион байгуулах
- Зайн сургалтыг алслагдсан орон нутгийн эмч, мэргэжилтний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд өргөнөөр ашиглах
- Эрүүл мэндийн цахим мэдээлэл, сурталчилгаа явуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.3:** Цахим эрүүл мэнд хөтөлбөр, зайн оношилгоо, эмчилгээний технологийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах

*Хүрэх үр дүн: Цахим эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Түргэн тусламжийн үндэсний сүлжээний байгууллагуудын уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх
- Эрүүл мэндийн мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн ашиглалтын хэрэгцээг тогтоох, өргөжүүлэх
- Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3:**

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийг дэмжих үйл ажиллагааны арга зүйг боловсронгуй болгох

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3.1:**

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зохион байгуулалтыг сайжруулах

*Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын зохион байгуулалт сайжирсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Салбарын хүний нөөцийн мэдээний нэгдсэн сан бүрдүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах
- Сургалт эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах
- Салбарын удирдах ажилтны сургалт зохион байгуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3.2:**

Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг шинэчлэх

*Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа шинэчлэгдэж, хууль, эрх зүйн хэм хэмжээнд зохион байгуулагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах
- Зөвшөөрлийн шалгалтыг цахимжуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3.3:**

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, ёс зүйн үнэлгээг боловсронгуй болгох

*Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг, ёс зүйн үнэлгээ боловсронгуй болж, дээшилсэн байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг үнэлэх, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4.**

Эм, эм хангамжийн байгууллага, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинэчлэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4.1:** Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийг сайжруулах

*Хүрэх үр дүн: Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн бүртгэл судалгаа сайжирч, мэдээний сан баяжигдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмийн бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээний сан үүсгэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4.2:** Импорт экспортын лицензийн хяналтыг боловсронгуй болгох

*Хүрэх үр дүн: Импорт, экспортын лиценз олголт, түүний хяналт сайжирсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуурт лиценз олгох ажлыг зохион байгуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4.3:** Эмийн гаж нөлөөний бүртгэл, тандалт судалгааг хөгжүүлэх

*Хүрэх үр дүн: Эмийн гаж нөлөөний бүртгэл судалгаа хийгдэж, эмнэлгийн мэргэжилтнүүд арга зүйгээр хангагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмийн гаж нөлөөний бүртгэл, хяналт үнэлгээ хийх
- Эмийн тандалт судалгаа, эмнэл зүйн судалгааны хяналт хийх
- Эмийн маркетингийн хяналтыг хийх
- Эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4.4:** Эм зүйн салбарын зохицуулалт, засаглалыг сайжруулах

*Хүрэх үр дүн: Эм зүйн салбарын ил тод байдал хангагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Эмийн сайн засаглалыг бэхжүүлэх

## **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5:**

Байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг ханган, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх



**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.1:**

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын ил тод байдлыг ханган, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах

*Хүрэх үр дүн: Байгууллагын төлөвлөлт, тайлагнах үйл ажиллагаа сайжран, үр дүн дээшилсэн байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Төвийн үйл ажиллагааны төлөвлөлтийн үр дүнг тооцох
- Төвийн үйл ажиллагааны хамтын ажиллагааг хангах
- Төвийн үйл ажиллагааны тайлагналтыг зохион байгуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2:**

Хүний нөөцийг манлайллыг дээшлүүлэх

*Хүрэх үр дүн: Байгууллагын хүний нөөц чадавхижиж, нийгмийн асуудал шийдэгдсэн байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Хүний нөөцийг чадавхижуулах
- Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
- Хүний нөөцийн гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлэх
- Хүний эрх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.3:**

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах

*Хүрэх үр дүн: Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хууль, эрх зүйн зөрчилгүй явагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Байгууллагын санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах
- Эд хөрөнгийн бүртгэл, тайлан тооцооны үйл ажиллагааг цахимжуулах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.4:**

Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний суралцах ахуйн орчинг сайжруулах

*Хүрэх үр дүн: Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүд тав тухтай орон байраар хангагдсан байна.*

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтад суралцах хугацаанд амьдрах ахуйн орчинг сайжруулах

СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1 Бодлого, шийдвэрийн нотолгоо, мэдээллийн чанарыг сайжруулах		ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД	ХУГАЦАА (Оноор)					ҮР ДҮН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
			2015	2016	2017	2018	2019		
1.1	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Эрүүл мэндийн бодлогын судалгааг өргөжүүлэн, хөгжүүлэх		+	+	+	+	+	Оновчтой бодлого, шийдвэр гарах нотолгоо бий болсон байна.	Нотолгоо, судалгаанд үндэслэсэн бодлого, шийдвэрийн эзлэх хувь Хийгдсэн бодлогын судалгааны тоо, төрөл
	<b>Үйл ажиллагааны чиглэл :</b> Эрүүл мэндийн салбарын тогтолцооны судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг мэдээ, мэдээллээр хангах								
1.1.1	Эрүүл мэндийн бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх ерөнхий аргачлал, арга зүйн үлгэрчилсэн загвар боловсруулж батлуулан, түгээх	СТСМА		+				Бодлогын судалгаа хийх батлагдсан аргачлал, арга зүйгээр хангагдсан байна.	Батлагдсан аргачлал Аргачлалаар хангагдсан байгууллагын тоо, төрөл
1.1.2	Батлагдсан аргачлалаар хэрэгцээ, шаардлагад үндэслэн тодорхой чиглэлээр бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх	СТСМА		+	+	+	+	Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид хэрэглэгчдийг баримт, нотолгоогоор хангах боломж бүрдсэн байна.	Судалгааны үр дүнгийн тайлангийн тоо, төрөл
1.1.3	Тусламж, үйлчилгээний хүлээгдэлд дүн шинжилгээ хийн, үр дүнг тайлагнах	СТСМА	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний хүлээгдлийн судалгаа хийж, үр дүнг танилцуулсан байна.	Дүн шинжилгээний тайлан Танилцуулж, тайлагнасан удаа Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ, гарсан үр дүн
1.1.4	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг олон улсын арга, аргачлалд нийцүүлэн судалж, бусад оронтой харьцуулах	СТСМА		+	+			Монгол эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадвар	Судалгааны аргачлал Үр дүнгийн тайлан

								судлагдсан байна.	
1.1.5	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн судалгаа хийх мэдлэг, ур чадварыг сайжруулах	СТСМА	+	+	+	+	+	Эмнэлгийн мэргэжилтний судалгаа хийх чадавхи сайжирсан байна.	Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо Сургалтын дараах үр дүн
<b>Үйл ажиллагааны чиглэл: Эрүүл мэндийн технологи, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, концессын төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлэх</b>									
1.1.6	Эрүүл мэндийн технологийн үнэлгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, аргачлал, арга зүйг шинэчлэн, батлуулах	СТСМА	+	+				Эрүүл мэндийн технологийн үнэлгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийгдэж, батлагдсан аргачлал, арга зүйгээр хангагдсан байна.	Судалгааны үр дүнгийн тайлан Үр дүнг танилцуулсан байдал Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ Батлагдсан аргачлал Түгээсэн байдал
1.1.7	Батлагдсан арга, аргачлалаар технологийн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулж, шийдвэр гаргагч нарыг мэдээ, мэдээллээр хангах	СТСМА			+	+	+	Эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийгдсэн байна.	Технологийн үнэлгээний үр дүнгийн тайлан Үр дүнг танилцуулж, хүлээлгэж өгсөн байдал Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
1.1.8	Элэгний өвчнөөс урьдчилан сэргийлэх болон элэг шилжүүлэн суулгах технологийн үнэлгээ хийж, үр дүнг хүлээлгэж өгөх	МСЗ СТСМА		+	+			Технологт үнэлгээ хийгдсэн байна.	Батлагдсан аргачлал Үнэлгээний тайлан
1.1.9	Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийх аргачлал батлуулан, үнэлгээ хийх	ЭМСЯ, СТСМА	+					Бодлогын хэрэгжилтийн үнэлгээний аргачлал батлагдаж, үнэлгээ хийгдсэн байна.	Үнэлгээ хийх батлагдсан аргачлал Үнэлгээний тайлан Танилцуулсан байдал, гарсан шийдвэр
1.1.10	Технологийн шинэчлэлийг тэргүүлэх чиглэлээ							Тусламж,	Дэмжиж, хамтарч

	болгосон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг дэмжин, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, концессын төслийн хэрэгжилтийг хангах	ЭМСЯ, СТСМА	+	+	+	+	+	үйлчилгээний чанар, хүртээмж түншлэлийн өмнөх түвшингээс сайжирч, төсөвт үзүүлэх дарамт буурсан байна.	ажилласан байгууллага, тусламж үйлчилгээний тоо, төрөл Гарсан үр дүн, дүгнэлт
1.1.11	Эрүүл мэндийн байгууллагуудын сайн туршлага, алдаа зөрчлийн мэдээллийг цуглуулах цахим сан бүрдүүлэх, боловсронгуй болгох	СТСМА	+	+	+	+	+	Цахим сантай болсон байна.	Тогтвортой ажиллаж байгаа цахим сан Цахим сангийн баяжилт, он, оноор
1.1.12	Эрүүл мэндийн байгууллагуудад бүртгэгдсэн алдаа зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийн, мэдээний чанар, бодит байдлыг сайжруулах	СТСМА	+	+	+	+	+	Алдаа зөрчлийн мэдээний чанар сайжирсан байна.	Хийгдсэн дүн шинжилгээний тоо, танилцуулсан байдал Мэдээний чанарт гарсан ахиц, дэвшил
1.1.13	“Алдаа зөрчлийн мэдээг бүртгэх, дүгнэлт хийж, эргэн мэдээлэх журам”-ыг боловсронгуй болгох	СТСМА	+	+				Журам шинэчлэгдсэн байна.	Хүргүүлсэн санал Шинэчлэгдэн батлагдсан журам
1.1.14	Эрүүл мэндийн байгууллагуудын Чанарын албаны дарга, менежерүүдэд сургалт хийж, арга зүйгээр хангах	СТСМА		+				Мэдлэг ур чадвар сайжирсан байна.	Зохион байгуулсан сургалтын тоо, тайлан Хамрагдсан чанарын менежерийн тоо Арга зүйн удирдлагаар хангасан байдал
1.2	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> <b>Эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээг сайжруулах</b>		+	+	+	+	+	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн сайжирсан байна.	Эрүүл мэндийн үндэсний тооцооны үр дүнг шийдвэр гаргалтад ашигласан байдал Тусламж үйлчилгээний зардал, үр ашигт дүн шинжилгээ хийн ажилласан байдал
	<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Эрүүл мэндийн нийт зардлын үндэсний тооцоо, санхүүжилтийн дүн шинжилгээ хийж хэрэглэгчдийг мэдээллээр хангах</b>								
1.2.1	ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийн болон ажлын залгамж холбоог алдагдуулахгүй байх зохион байгуулалтын бүтцийг бий болгох	ЭМСЯ, СТСМА		+	+			ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүхий зохион	ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтний тоо, бүтэц

								байгуулалтын бүтэц бий болсон байна.	
1.2.2	ЭМҮТ-д шаардагдах олон талын салангид тайлан, мэдээллүүдийг нэгтгэх мэдээллийн урсгалыг бий болгож, албажуулах	ЭМСЯ, СТСМА	+	+				ЭМҮТ-д шаардагдах мэдээллийн урсгалыг зохицуулах эрх зүйн зохицуулалт бий болсон байна.	Мэдээллийн урсгалын батлагдсан журам
1.2.3	ЭМҮТ-ны үзүүлэлтүүдийг гаргахад зайлшгүй шаардлагатай судалгаануудын жагсаалтыг гаргаж, тогтмол, тодорхой давтамжтайгаар хийх ажлыг зохион байгуулах	СТСМА	+	+	+	+	+	Шаардлагатай судалгаанууд тогтмол, тодорхой давтамжтайгаар хийгдсэн байна.	Судалгааны жагсаалт Хийгдсэн судалгааны тоо ба давтамж Үр дүнг танилцуулсан байдал Мэдээллээр хангасан байдал
1.2.4	Нэмэлт судалгаануудыг тогтмол хийхэд шаардагдах гадаад, дотоод санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтмолжуулах	ЭМСЯ, СТСМА		+	+	+	+	Шаардлагатай судалгаанууд гадаад дотоодын санхүүгийн эх үүсвэрээс санхүүжсэн байна.	Хүсэлт тавьсан байгууллагын тоо, төрөл Гарсан үр дүн Санхүүжилтийн хэмжээ
1.2.5	ЭМҮТ, эдийн засгийн дүн шинжилгээ хариуцсан нэгжийн техникийн болон ур чадварыг тогтмол нэмэгдүүлэх	СТСМА			+	+	+	ЭМҮТ-ны асуудал хариуцсан мэргэжилтнүүд орчин үеийн тооцооллын техник хэрэгсэлээр хангагдаж, чадавхжсан байна.	Шаардлага хангасан техник хэрэгслийн тоо Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо
1.2.6	Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах талаар сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах	СТСМА			+	+	+	Бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчид ЭМҮТ-ны үр дүнг хэрхэн ашиглах	Зохион байгуулсан сургалтын тоо, давтамж, тайлан Хамрагдсан шийдвэр гаргагчдын тоо ЭМҮТ-ны үр дүнг

								талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	ашиглан боловсруулсан бодлого, шийдвэрийн тоо
1.2.7	ЭМҮТ-ны ангилал, кодчиллыг сайжруулан шинэчилж, ангиллын тайлбар, тооцох аргачлалыг батлуулах	ЭМСЯ, СТСМА	+	+				ЭМҮТ-ны ангилал, кодчиллыг сайжруулан шинэчилж, ангиллын тайлбар, тооцох аргачлал батлагдсан байна.	Батлагдсан тушаал, журам
1.2.8	Мэдээллийн бүхий л эх үүсвэрүүдээс холбогдох мэдээллүүдийг цуглуулж мэдээллийн нэгдсэн сан үүсгэх	СТСМА	+	+	+	+	+	ЭМҮТ-ны мэдээллийн сан бүрдсэн байна.	Тогтвортой ажиллагаатай мэдээллийн сан, түүний баяжилт Цуглуулсан мэдээллийн тоо, төрөл Сангийн мэдээллийг ашиглаж буй байдал
1.2.9	ЭМҮТ-ны тооцоололд ашиглагдаж буй олон улсын програм хангамжийг ашиглан ЭМҮТ-ны үр дүнг боловсруулж, дүн шинжилгээ хийх	СТСМА	+	+	+	+	+	ЭМҮТ-ны үр дүнг ЭЗХАХБ-ын стандартаар боловсруулсан байна.	Стандартаар боловсруулсан ЭМҮТ-ны үр дүнгийн тайлан, эмхэтгэл Танилцуулж, түгээсэн байдал
1.2.10	Тусламж, үйлчилгээний өртгийг төрөл бүрийн хэлбэр, аргаар тооцон, харьцуулалт хийх	СТСМА	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний өртгийн тооцоолол бодитой болсон байна.	Ашигласан арга, хэлбэр Хийгдсэн тооцоо, судалгааны үр дүнгийн тайлан Танилцуулж, түгээсэн байдал Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
1.2.11	Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үр ашгийн тооцоо судалгааг тогтмол хийх	СТСМА	+	+	+	+	+	Эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үр ашгийн талаарх мэдээлэлтэй	Хийгдсэн тооцоо, судалгааны давтамж, тоо, тайлан Үр дүнг танилцуулсан байдал

									болсон байна.	Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
1.2.12	Эрүүл мэндийн эдийн засгийн үр ашгийн тооцооллуудыг ашиглан тусламж үйлчилгээний үр ашгийг тогтмол тодорхой давтамжтайгаар тооцох	СТСМА	+	+	+	+	+		Тусламж, үйлчилгээний үр ашиг тооцогдсон байна.	Хийгдсэн тооцоо, судалгааны давтамж, тоо, тайлан Үр дүнг танилцуулсан байдал Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
1.3	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Эрүүл мэндийн статистик мэдээллийн агуулгыг боловсронгуй болгож, чанарыг сайжруулах		+	+	+	+	+		Эрүүл мэндийн статистик мэдээллийн чанар сайжирсан байна.	Шинэчилж боловсронгуй болгосон эрүүл мэндийн үзүүлэлтийн төрөл, тоо, тушаал шийдвэр Олон улсын мэдээллийн санд нэмж оруулсан үзүүлэлтийн төрөл, тоо
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Өвчний олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хэрэглээг сайжруулах ажлыг зохион байгуулах</b>										
1.3.1	Үндэсний түвшинд тооцох эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэн, боловсронгуй болгох	ЭМСЯ, СТСМА	+	+	+	+	+		Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал боловсронгуй болсон байна.	Боловсронгуй болж, батлагдсан аргачлал, үзүүлэлтийн тоо, давтамж
1.3.2	Эрүүл мэндийн сар, улирал, жилийн статистикийн үзүүлэлтүүдийн эмхэтгэлийг бусад орны түвшинд ойртуулан, боловсронгуй болгох	СТСМА	+	+	+	+	+		Эрүүл мэндийн статистик мэдээний эмхэтгэл шинэчлэгдсэн байна.	Шинэчлэгдсэн эмхэтгэлийн төрөл, тоо, давтамж Боловсронгуй болсон байдал, хэлбэр, тайлан
1.3.3	Эрүүл мэндийн мэдээний бүртгэл, тайлангийн маягыг өөрчлөлт, хөгжилтэй нийцүүлэн тогтмол шинэчилж боловсронгуй болгох, түгээх	ЭМСЯ, СТСМА	+		+		+		Эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягт шинэчлэгдсэн байна.	Шинэчлэгдсэн бүртгэл, тайлангийн маягтын төрөл, тоо, давтамж Батлагдсан тушаал Танилцуулсан байдал Тарааж, түгээсэн байдал
1.3.4	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн мэдээ тайлангийн чанарт тогтмол хяналт хийн, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	СТСМА	+	+	+	+	+		Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын	Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо,

								мэдээний чанар сайжирсан байна.	төрөл Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн тайлан Гарсан зөвлөмж, түүний биелэлт, эргэх холбоо Арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байдал
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Хүн амын эрүүл мэндийн мэдээний нэгдсэн цахим сан бүрдүүлэх, програм хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах</b>									
1.3.5	Health-Info 3.0 програм хангамжийн нэвтрэлтийг бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад жигдрүүлэх	СТСМА	+	+				Эрүүл мэндийн мэдээлэл хугацаандаа, үнэн зөв, бүрэн цугларч, нэгтгэгдсэн байна.	Програм хангамжийг бүрэн нэвтрүүлсэн байгууллагын тоо, төрөл
1.3.6	Эрүүл мэндийн статистикийн сарын мэдээний программ хангамжийн нэвтрэлтийг бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад жигдрүүлэх	СТСМА	+	+				Эрүүл мэндийн сар бүрийн мэдээлэл хугацаандаа, үнэн зөв, бүрэн цугларч, нэгтгэгдсэн байна.	Програм хангамжийг бүрэн нэвтрүүлсэн байгууллагын тоо, төрөл
1.3.7	Сумдаар эрүүл мэндийн статистикийн мэдээний санг үүсгэж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	СТСМА	+	+	+	+	+	Шийдвэр гаргагчдыг засаг захиргааны нэгжийн түвшний мэдээллээр хангадаг болсон байна.	Мэдээний сан, түүний баяжилт, мэдээллийн төрөл, тоо
1.3.8	Жирэмсний эрт хяналт, бүртгэл, тандалтын цахим програм бий болгох, нэвтрүүлэх	СТСМА		+	+	+		Жирэмсний бүртгэл, хяналт сайжирсан байна.	Цахим програм Оруулсан мэдээлэл
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах</b>									
1.3.9	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн мэргэжилтэн статистикч их, бага эмч	СТСМА	+	+	+	+	+	Мэдээллийн мэргэжилтнүүд	Зохион байгуулсан сургалтын тоо,



	нарыг чадавхижуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах								чадавхижсан байна.	хамрагдсан хүний тоо
1.3.10	Бүх түвшний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарын нотолгоонд суурилсан шийдвэр гаргах ур чадварыг сайжруулах	ЭМСЯ, СТСМА	+	+	+	+	+		Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт сайжирсан байна.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2:</b> Эрүүл мэндийн технологи, зайн анагаах ухааныг хөгжүүлэх		<b>ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД</b>	<b>ХУГАЦАА (Оноор)</b>					<b>ҮР ДҮН</b>	<b>ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>	
			2015	2016	2017	2018	2019			
2.1	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, шалгалт болон засвар тохируулгыг өргөжүүлэх		+	+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл хийгдэж, шалгалт болон засвар тохируулга хийгдсэн байна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан, түүний баяжилт, төрөл, тоо Хийгдсэн шалгалт болон засвар тохируулгын төрөл, тоо	
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх										
2.1.1	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн холбогдох журмууд боловсруулж, шинэчлэн, хэрэгжүүлэх	ЭМСЯ, МХЕГ, СХЗГ, МТЭТТА	+	+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн эрх зүйн баримт бичигтэй болсон байна.	Батлагдсан журам	
2.1.2	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн Монгол улсын MNS стандарт боловсруулж эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх	ЭМСЯ, МХЕГ, СХЗГ, МТЭТТА		+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн Монгол улсын MNS стандарттай болсон байна.	Монгол улсын MNS стандартын тоо	
2.1.3	Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлогыг хэрэгжүүлэх	МТЭТТА	+	+	+	+	+	Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлого хэрэгжсэн байна	Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлогын хэрэгжилтийн тайлан	
2.1.4	Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга болон засвар тохируулга хийх анализатор,	МТЭТТА		+	+	+	+	Шалгалт тохируулгын цар	Анализатор болон симуляторын тоо	

	симуляторын тоо хэмжээг нэмэгдүүлэх							хүрээ өргөжсөн байна	
2.1.5	Эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, багажийн нэршлийн нэгдсэн систем боловсруулж, эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх	ЭМСЯ, ШУТИС, АШУУИС, МТЭТТА	+	+	+	+		Эрүүл мэндийн салбарт Эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, багажийн нэгдсэн нэршилтэй болсон байна.	Нэршлийн эмхтгэл
2.1.6	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох хууль эрх зүйн орчинг бий болгох	ЭМСЯ, МТЭТТА		+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарын мэргэжлийн ур чадвар сайжирсан байна.	Судалгааны тайлан Батлагдсан журам Ажлын тайлан
<b>Үйл ажиллагааны чиглэл: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн сан үүсгэж, шалгалт болон засвар тохируулга хийх</b>									
2.1.7	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх	МТЭТТА	+	+	+	+	+	Холбогдох байгууллагууд мэдээллээр хангагдсан байна.	Ажлын тайлан
2.1.8	Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх	МТЭТТА	+	+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай үйл ажиллагаа хангагдсан байна.	Ажлын тайлан
2.1.9	Эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар тохируулга хийх	МТЭТТА	+	+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагаа хангагдсан байна.	Ажлын тайлан
<b>Үйл ажиллагааны чиглэл: Тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах</b>									

2.1.10	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарын төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах	ШУТИС, АШУУИС, МТЭТТА		+	+	+	+	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарын мэргэжлийн ур чадвар сайжирсан байна.	Сургалтын хөтөлбөр Сургалтын төрөл, тоо Хамрагдагсдын тоо Сургалтын тайлан
2.1.11	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл, сурталчилгаа явуулах	МТЭТТА	+	+	+	+	+	Олон улсад нэвтэрч буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл түгээгдсэн байна.	Мэдээллийн тоо
2.2	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Телемедициний үйлчилгээг өргөжүүлэх		+	+	+	+	+	Телемедициний үйлчилгээний нэр төрөл олширч, тоо хэмжээ нэмэгдсэн байна.	Нэр төрлийн тоо
<b>Үйл ажиллагааны чиглэл: Зайн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг зохион байгуулах</b>									
2.2.1	Мэдээллийн технологи, телемедициний чиглэлээр “Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах” төслийн багтай хамтран ажиллаж, телемедициний нэгдсэн сүлжээнд холбох	МТЭТТА, ҮОЭТ	+	+	+			Үндэсний оношилгоо, эмчилгээний төв телемедицинтэй болсон байна.	Уулзалт, ярилцлагын тоо
2.2.2	Дүрс дамжуулах, хадгалах PACS системийг нэвтрүүлэх	ЭМСЯ, МТЭТТА, ҮОЭТ			+	+	+	Дүрс хадгалах, дамжуулах нэгдсэн технологитой болсон байна.	PACS систем нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо
2.2.3	Сумын ЭМТ, сум дундын эмнэлэгт телемедицинийг хөгжүүлэх	ЭМСЯ, МТЭТТА			+	+	+	Сумын ЭМТ, сум дундын эмнэлэгт телемедицинийг хөгжүүлэх саналыг ЭМСЯ-нд хүргүүлсэн байна.	Хэрэглэж болох програм хангамж, хэрэглэгдэхүүний нэр, тоо
2.2.4	Зайн анагаах ухааны үндэсний сүлжээнд суурилсан эмнэлгийн яаралтай тусламжийг хөгжүүлэх	МТЭТТА	+	+	+	+	+	Эмнэлгийн яаралтай	Эрүүл мэндийн байгууллагын тоо

									тусламжид телемедицин ашигладаг болсон байна.	
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b>										
<b>Зайн сургалтыг алслагдсан орон нутгийн эмч мэргэжилтний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд өргөнөөр ашиглах</b>										
2.2.5	Эмч, эмнэлгийн ажилтнуудад сургалт явуулах, зайны сургалтын арга, технологийг өргөнөөр ашиглахад дэмжлэг үзүүлэх	ЭМХА, МТЭТТА	+	+	+	+	+	+	Алслагдсан орон нутгийн эмч эмнэлгийн мэргэжилтэн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх боломжтой болсон байна.	Сургалтын тоо
2.2.6	Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан зайн сургалтын програм хангамжийг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах	ЭМХА, МТЭТТА	+	+	+	+	+	+	Сургалтын үр өгөөж сайжирч, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдсэн байна.	Програм хангамжийн нэр, тоо
2.2.7	Төгсөлтийн дараах сургалтаар мэргэжил дээшлүүлсэн эмч эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийн мэдээний сангийн програм хангамжийг боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлэх	МТЭТТА, ЗААА	+	+					Нарийн мэргэжил эзэмшсэн хүний нөөц бэлтгэх бодлого боловсруулах мэдээний сантай болсон байна.	Програм хангамжийн нэр, тоо
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b>										
<b>Эрүүл мэндийн цахим мэдээлэл, сурталчилгаа явуулах</b>										
2.2.8	Хүн амд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн цахим хуудас ажиллуулах	МТЭТТА	+	+	+	+	+	+	Эрүүл мэндийн мэдээллийг олон нийтэд хүргэх боломж нэмэгдсэн байна.	Ажиллуулж буй цахим хуудсын тоо, тавьсан мэдээлэл, төрөл
2.3	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Цахим эрүүл мэнд хөтөлбөр, зайн оношилгоо, эмчилгээний технологийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах		+	+	+	+	+	+	Цахим эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

	<b>Үйл ажиллагааны чиглэл: Түргэн тусламжийн үндэсний сүлжээний байгууллагуудын уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх</b>									
2.3.1	“Цахим эрүүл мэнд” стратегийн үйл ажиллагааг 2015 – 2019 онд хэрэгжүүлэх ажлын албаны үүрэг гүйцэтгэх	ЭМСЯ, МТЭТТА	+	+	+	+	+	Стратеги хэрэгжсэн байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	
2.3.2	Түргэн тусламжийн үйлчилгээнд зайн анагаах ухааны технологийг хэрэгжүүлэх	МТЭТТА			+	+	+	Түргэн тусламжийн үйлчилгээнд телемедицин нэвтэрсэн байна.	Эрүүл мэндийн байгууллагын тоо	
	<b>Үйл ажиллагааны чиглэл: Эрүүл мэндийн мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн ашиглалтын хэрэгцээг тогтоох, өргөжүүлэх</b>									
2.3.3	Эрүүл мэндийн мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн бүртгэлийн нэгдсэн сантай болох, баяжуулах	МТЭТТА		+	+	+	+	Нэгдсэн сантай болсон байна.	Сангийн мэдээлэл	
2.3.4	Эрүүл мэндийн салбарын энтерфрайз архитектурын салбарын мэдээний сангийн зураглалыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх	ЭМСЯ, МТЭТТА			+	+		Эрүүл мэндийн салбар энтерфрайз архитектуртай болсон байна.	Мэдээний сангийн зураглал	
	<b>Үйл ажиллагааны чиглэл: Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах</b>									
2.3.5	Эрүүл мэндийн мэдээллийн технологи, телемедициний мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах	МТЭТТА, ЗААА, ЭМХА		+	+	+	+	Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар сайжирсан байна.	Зохион байгуулсан сургалтын төрөл, тоо, хамрагдагсдын тоо Сургалтын тайлан	
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3:</b>		<b>ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД</b>	<b>ХУГАЦАА (Оноор)</b>					<b>ҮР ДҮН</b>	<b>ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>	
<b>Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийг дэмжих үйл ажиллагааны арга зүйг боловсронгуй болгох</b>			<b>2015</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>			
3.1	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ</b> Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зохион байгуулалтыг сайжруулах		+	+	+	+	+	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын	Зохион байгуулалтыг сайжруулахаар хийгдсэн арга хэмжээний тайлан Батлагдсан шийдвэр, журам, тушаал	

									зохион байгуулалт сайжирсан байна.	
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Салбарын хүний нөөцийн мэдээний нэгдсэн сан бүрдүүлэх</b>										
3.1.1	Салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах	ЭМСЯ, ЭМХТ МТЭТТА	+	+	+	+	+	Салбарын хүний нөөцийн нэгдсэн сантай (Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт, мэргэжлийн ур чадвар) болсон байна.	Үүссэн сан, мэдээллийн баяжилт, төрөл, тоо Санг нэвтрүүлсэн байгууллагын төрөл, тоо	
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b> <b>Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах</b>										
3.1.2	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох	ЭМСЯ, ЭМХА, ЭМСЗ		+	+			Эмнэлгийн мэргэжилтний салбар зөвлөл, сургалт зохион байгуулах нийгэмлэг холбоодын оролцоог сайжруулан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө чанартай боловсронгуй болсон байна.	Батлагдсан сургалтын хөтөлбөрийн тоо, төрөл	
3.1.3	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гадаад хэлний түвшинг дээшлүүлэх тасралтгүй сургалтыг зохион байгуулж, хэвшүүлэх	СЭБ ЭМХА	+	+	+	+	+	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн эмнэлгийн гадаад хэлний	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдагсадын тоо Эмнэлгийн гадаад	

								мэдлэг сайжирсан байна.	хэлний мэдлэгийн түвшингийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсэн байдал
3.1.4	Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд мэргэжлийн нийгэмлэг, холбоод, салбар зөвлөлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах	ЭМХЗ/ЭМСЯ ЭМХА, нийгэмлэг, холбоод	+	+	+	+	+	Чанарын шаардлага хангасан сургалтын хөтөлбөртэй болсон байна.	Батлагдсан сургалтын хөтөлбөрийн тоо Хамтарч ажилласан байгууллагууд
